



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/304

Мандалговь

Журам шинэчлэн
батлах тухай

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын 1, 3 дахь заалт, 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн 1.1, 1.6, 1.7 дахь заалтууд, 2018 оны 258 дугаар тогтоолын 1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 36, 2019 оны 5 дугаар хуралдаануудын тэмдэглэл, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр 3-ны өдрийн 6 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч барагдуулах, шийдвэрлэлтэнд хяналт тавих, мэдээлэх журам”-ыг шинэчлэн баталсугай.

Хоёр. Тус журмыг аймаг, сум, агентлаг, газар, алба, хэлтсийн удирдлагууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

Гурав. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Тус журам батлагдсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 16 дугаар (Журам батлах тухай) тушаалыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190884